


ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Баавгайн зах зээлийн уналт ба дараагийн 12 сарын өсөлт



- Хөрөнгийн зах зээл өнгөрсөн 7 хоногийг өсөлттэй үдэж, 3 долоон хоног үргэлжилсэн уналтаас гарлаа.
- Шинжээчид одоо инфляцыг цаашид буурна гэж харж байна.
- Баавгайн зах зээлийг туулахад хэдийгээр тэсвэр шаарддаг боловч хүчтэй өсөлт дараа нь үргэлжилдэг.

2022.09.12-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	32,161.00	0.03%	2.31%	-5.16%	-7.77%
US500	4,066.46	-0.02%	3.61%	-5.38%	-9.01%
NASDAQ	12,585.85	-0.03%	3.75%	-7.93%	-18.47%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	7,351.00	1.23%	0.96%	-2.08%	4.58%
DE40	13,088.00	1.43%	0.29%	-4.47%	-16.15%
FR40	6,212.00	1.41%	0.73%	-4.77%	-6.77%
IT40	22,095.00	1.92%	0.79%	-2.68%	-13.98%
ES35	8,033.00	1.47%	1.27%	-3.83%	-7.62%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	28,529.00	1.06%	3.33%	-1.16%	-6.30%
SHANGHAI	3,262.00	0.82%	2.37%	0.99%	-11.91%
CSI 300	4,094.00	1.39%	1.74%	-0.39%	-18.35%
SHANGHAI 50	2,758.00	1.82%	1.71%	0.97%	-15.21%
CH50	13,416.87	1.68%	0.90%	0.19%	-13.98%
SENSEX	59,793.00	0.18%	1.68%	1.66%	2.78%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	85.34	-1.68%	-3.85%	-3.91%	21.18%
Газрын тос (Brent)	91.37	-1.60%	-4.53%	-3.05%	24.35%
Байгалийн хий	8.09	1.14%	-7.55%	-7.33%	54.62%
Шатахуун	2.40	-1.15%	-2.97%	-11.24%	11.32%
Нүүрс	435.25	-1.08%	0.06%	9.18%	145.07%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,713.87	-0.13%	0.20%	-3.67%	-4.45%
Мөнгө	18.86	0.43%	3.85%	-6.88%	-20.47%
Зэс	3.55	-0.83%	3.11%	-2.21%	-18.67%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.3193	0.0017	0.09%	0.53%	1.99%
Англи	3.0950	0.0520	0.18%	1.14%	2.34%
Швейцар	1.0290	0.0670	0.16%	0.59%	1.30%
Испани	2.8660	0.0310	0.14%	0.86%	2.53%
Герман	1.7000	0.0120	0.18%	0.81%	2.03%

2022 оны жилийн эцсийн байдлаарх хүлээлт ба бодит байдал

Хөрөнгийн зах зээл өнгөрсөн 7 хоногийг өсөлттэй үдэж, 3 долоон хоног үргэлжилсэн уналтаас гарлаа. Одоо бодлогын хүү, инфляцаас шалтгаалж цаашдын эдийн засаг хэр байх нь тодорхой болно. 2022 он дуусах ойртож байгаа тул энэ жилийн эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл болон бодит байдлыг харцгаая.

1. Эдийн засгийн өсөлт

2022 оны хүлээлт: Хөл хорионоос гарснаар эдийн засаг сэргэнэ гэсэн төсөөлөлтэй байв

- Цар тахал, хөл хорионоос болж олон улсын эдийн засагт урьд өмнө үзэгдэж байгаагүй хэмжээний бэрхшээлтэй нүүр тулсан. Жишээлбэл, олон улсын нийлүүлэлтийн саатал, түүхэн дээд хэмжээний өрхийн хадгаламж, барааны худалдан авалт үйлчилгээнээс илүү байсан.
- Нийлүүлэлтийн саатал шийдэгдэж, мөнгөн халамж, хадгаламжаараа худалдан авалт хийх зэрэг нь эдийн засгийн өсөлтийг хадгалж үлдэхэд хангалттай байх болно гэсэн төсөөлөлтэй байв.

2022 оны бодит байдал: Эдийн засаг эхний хагас жилд агшив

- ДНБ-ний өсөлт эхний хоёр улирал дараалан унаснаар эдийн засгийн талаарх яриа сэргэлтээс хямрал руу бушуухан орсон. Хоол, хүнс болон эрчим хүчний үнэ өсөж, худалдан авалт буурсан боловч эдийн засаг олон нийтийн ярьж байгаагаас харьцангуй илүү тэсвэртэй байж магадгүй.
- АНУ-ын ДНБ-ний 70%-ийг эзэлдэг өрхийн худалдан авалт бодлогын хүү болон инфляц өсөж байсан ч энэ жил тогтвортой хэмжээнд байлаа. ДНБ эхний хагас жилд бараа материалын үлдэгдэл болон гадаад худалдааны тэнцлээс болж ихээхэн савлагаатай байсан.
- Нийлүүлэлтийн түгээлт сайжирснаар нийлүүлэлтийн саатлаас ангижрахад тусалсан. Сүүлийн үед хүмүүс гадуур хооллох, аялах зэрэг нэмэгдсэнээр үйлчилгээнд зарцуулах дүн өссөн.

Цаашдын төсөөлөл:

- Шинжээчдийн үзэж байгаагаар ДНБ-ний өсөлт оны эцэс гэхэд буцаад эерэг болох боловч мөнгөний бодлого хатуу хэвээр байна. Хэрвээ эдийн засаг хямралд орох юм бол харьцангуй богино хугацаанд үргэлжилнэ гэж харж байна. Үүний шалтгаан нь өмнөх хямралд тохиож байсан шиг санхүүгийн тэнцвэргүй байдал эсвэл хүчтэй уналт одоогоор тохиогоогүй байгаа тул.

Хэрэглээний өсөлт (улирлаар)



2. Хөдөлмөрийн зах зээл

2022 оны хүлээлт: Ажилгүйдлийн түвшин 4%-иас доош оров

- Бүтэн хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны эрэлт өндөр байсан тул хөдөлмөрийн зах зээл энэ жил их сайн байлаа.
- Шинжээчид 2022 онд ажилгүйдлийн түвшнийг 2021 оны 5.4%-иас 4% болно гэж төсөөлсөн.

2022 оны бодит байдал: Ажилгүйдлийн түвшин сүүлийн 50 жилд үзэгдээгүй доод хэмжээнд хүрсэн

- Хөдөлмөрийн зах зээл дээрх төсөөллөөс ч илүү сайн байсан нь бодлогын хүүгийн өсөлт болон худалдан авалт ихээхэн нэмэгдсэнтэй холбоотой байв. Нийт ажлын байрны тоо цар тахлаас өмнөх түвшинд хүрсэн.
- Ажилгүйдлийн түвшин одоогийн байдлаар 3.7%-тай байна. Шинээр зарлагдсан ажлын байрны тоо 11 саяыг давсан нь эрэлт өндөр байгааг харуулж байгаа ба цалингийн хэмжээг өсгөсөөр байна.

Цаашдын төсөөлөл:

- Эдийн засаг унаж байгаа, байгууллагууд (ялангуяа технологийн салбар) нэмж ажлын байр зарлахгүй байгаа зэрэг нь хөдөлмөрийн зах зээлийн өсөлтийг бууруулна.
- Шинжээчид цаашдын ажлын байрны өсөлтийг саарч, цалингийн өсөлтийг мөн буурна гэж харж байна.
- Том дүр зургаар харвал, хөдөлмөрийн зах зээл сайн байснаар өрхийн хэрэглээ өсөж, цаашлаад эдийн засгийг дэмжихэд чухал нөлөө үзүүлнэ.

3. Инфляц

2022 оны төсөөлөл: Инфляц 3%-иас дээш байх ба жилийн сүүлийн хагаст бууна.

- Инфляцын түвшин оны эхнээс 5%-тай байсан ба хурдтай өсөж байв. Шинжээчид эхний хагас жилд өсөөд, дараагийн хагасаас эхлэн нийлүүлэлт хэвийн болж, хэрэглээ тогтворжсоноор буурах болов уу гэж харж байсан.

2022 оны бодит байдал: Эрчим хүчний үнээс болж инфляц өссөөр байна.

- Хэдийгээр нийлүүлэлт буцаад хэв нь дээ орж байсан боловч түүхий эдийн ханш огцом өссөнөөр инфляц 9%-иас дээш гарч, аль ч шинжээчийн таамгийг эвдсэн юм.
- Урьдчилан таамаглах боломжгүй байсан Орос-Украины дайн улаан буудай болон газрын тосны ханшийг огцом өсөхөд нөлөөлсөн. Дээрээс нь БНХАУ-ын “тэг Ковид 19” бодлого нь олон улсын нийлүүлэлтийн асуудалд оруулсаар байв.
- Нэг авуштай зүйл нь сүүлийн 2 сард инфляцын түвшин буурч эхэлсэн. Харамсалтай нь өрхийн санхүүгийн байдал болон худалдан авалтын хандлагад ширүүхэн сөргөөр нөлөөлсөн.

Цаашдын төсөөлөл:

- Шинжээчид одоо инфляцыг цаашид буурна гэж харж байна. Түүхий эдийн ханш буурч байгаа, нийлүүлэлтийн хэмжээ өссөн, барааны үнэ буурч байгаа зэрэг нөлөөлсөн.

АНУ-ын инфляцын түвшин



4. ХНС-ийн мөнгөний бодлого

2022 оны хүлээлт: ХНС бодлогын хүүг өсгөх боловч өмнөх үеэс илүү багаар өсгөх болно.

- АНУ-ын бодлогын хүү 2022 оны эхэнд 0%-тай байсан бол инфляц хурдтай өссөнөөр ХНС бодлогын хүүг өсгөхөөс өөр аргагүй болсон. Шинжээчид 3 удаагийн 0.25%-ийн өсөлтийг хүлээж байв.
- ХНСанг 2016-2018 оны үеийн эдийн засгийн нөхцөл байдалд тохируулсан мөнгөний бодлого баримтална гэж төсөөлсөн.
- 2022 оны бодит байдал: ХНС түүхэнд үзэгдээгүй хурдтайгаар бодлогын хүүг өсгөсөн.
- Инфляц огцом өссөний үндсэн дээр ХНС урьд өмнө харагдаж байгаагүй хатуу мөнгөний бодлого баримталсан. Ингэснээр хөрөнгийн зах зээл эхний хагас жилд ихээхэн унасан.

Цаашдын дүр зураг:

- ХНС цаашдын эдийн засгийг тогтвортой байлгахын тулд инфляцыг эргээд хэвийн түвшинд аваачихаар бодлогын хүүг хэд л бол хэдээр өсгөх төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.
- Бодлогын хүү 2015-2018 оны хооронд өссөн хэмжээгээр нэмэгдсэн боловч хэд дахин богино хугацаанд гүйцэтгэсэн юм. Шинжээчид энэ сарын сүүлээр дахиад 0.75%-иар өсгөнө гэсэн хүлээлттэй байна.
- Шинжээчид одоо ХНСанг бодлогын хүүг ойролцоогоор 3.5%-4.0% хүртэл өсгөнө гэсэн төсөөлөлтэй байна. Энэхүү бодлогын өсөлт нь ХНС-ийн балансын агшилттай зэрэгцэж явагдаж байгаагийн үр нөлөө нь эдийн засагт хэсэг хугацааны дараагаас мэдрэгдэж эхлэх буй. Одоогоор шинжээчид бодлогын хүүгийн өсөлт 2023 онд зогсох байх гэж харжээ.

АНУ-ын бодлогын хүү



5. Хөрөнгийн зах зээл

2022 оны төсөөлөл: Хөрөнгийн зах зээлд уналт ирснээр эрсдэл өндөртэй бүтээгдэхүүнүүдийн хөөс хагарна.

- 2021 онд хөрөнгийн зах зээл асар их өссөн тул 2022 онд томоохон уналтуудтай тулгарна гэж харж байв.
- Ялангуяа хөөсрөлттэй байсан крипто зах зээл, meme хувьцаанууд, NFT, SPAC гэх мэт эрсдэлтэй хөрөнгүүд хамгийн хүчтэй унана гэж таамагласан.

2022 оны бодит байдал: Хөрөнгийн зах зээлд уналт тохиож, баавгайн зах зээл рүү орсон. Спекюляц ихтэй хөөсөрсөн салбарууд хамгийн их унав

- Уналт хөрөнгийн зах зээлд харьцангуй эрт эхэлсэн. Инфляц, хатуу мөнгөний бодлогоос болж хувьцаануудын ханш баавгайн зах зээлийн түвшин хүртэл унасан.
- Тэр дундаа технологийн салбарын хувьцаанууд эдийн засгийн уналт болон өндөр мөнгөний бодлогоос болж илүү унасан. Спекюляц ихтэй хувьцаанууд сайн чанарын хувьцаануудтай харьцуулахад илүү их унасан.
- Жилийн эхээс 20% унасан ч хөрөнгийн зах зээл 6 сарын ёроол түвшнээс 15% хүртэл өсөөд байна.

Цаашдын нөхцөл байдал:

- 6 сарын ёроол ханш нь эдийн засгийн уналтыг аль хэдий нь тусгасан тул нэмж урьдчилан таамаглашгүй зүйл тохиолдохгүй л бол хөрөнгийн зах зээл цаашид U хэлбэртэй сэргэлт үзүүлнэ.
- Сэргэлт үзүүлэхэд гол нөлөөлөх хүчин зүйлсээс дурдахад:
- Инфляц хэдэн сар дараалан унах
- Эдийн засаг болон бизнесүүдийн ашиг тогтвортой өсөх
- Компаниудын үнэлгээ хангалттай буурах. Сүүлийн байдлаар компаниудын үнэлгээ хангалттай буурсан гэж шинжээчид үзэж байна.

Баавгайн зах зээлийг туулахад хэдийгээр тэсвэр шаарддаг боловч хүчтэй өсөлт дараа нь үргэлжилдэг.

Баганан графикаар уналтыг үзүүлсэн бол шар цэгээр өсөлтийг харуулав

